

Нутаг дэвсгэрийн талаарх япон улсын баримтлах бодлого

Жаргалын Ганхуяг 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Дорно дахины хэлний тэнхимийн багш, Магистр, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-03-28

Засварласан - Revised:
2024-04-18

Хэвлэгдсэн - Published:
2024-05-25

gankhuyag@msue.edu.mn

ORCID: [0009-0000-1677-1895](https://orcid.org/0009-0000-1677-1895)



© 2024, Author(s)

Хураангуй: “Газар бол улсын үндэс” гэж Хүн гүрний хаан хэлсэн байдаг. Хүн төрөлхтөний түүхэнд овгийн байгуулал, өмчийн харилцаа, сүүлд төрт улс үүссэн цагаас хойш газрын нутгийн төлөөх тэмцэл тасралтгүй үргэлжлэлж ирсэн бөгөөд цаашид ч эцэс төгсгөлгүй үргэлжлэх нь гарцаагүй. Өнөө магадгүй амар амгалан, асуудлаа шийдсэн мэт харагдавч маргааш юу болохыг таашгүй. Хичнээн улс оронтой хиллэнэ, төдий чинээ асуудал үүсдэг ба эх газрын орнуудын төдийгүй далай тэнгисээр хүрээлэгдсэн улс орнуудыг энэхүү асуудлыг тойрч гарахгүй юм. Энэхүү илтгэлээрээ Япон улстай далай тэнгисийн хилийн маргаантай газар нутаг, нэршилийн асуудлыг хөндсөн болно.

Түлхүүр үг: нутаг дэвсгэрийн нэршил, Сан Францискогийн гэрээ, Гаагийн конвенц, нотолгоо

Удиртгал

Япон улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл улс бөгөөд 377826 км.кв бүхий газар нутагтай, Хоншю (60.3%), Хоккайдо (22 %), Кюүшю (9.5%), Шикоку (5%) - нийт газар нутгийн 97 хувийг эзлэх 4 том арал, мөн Рюүкюү ольтриг буюу Окинавагийн бүлэг арлууд гээд нийтдээ 4917 ш (1982 он), 6847 ш (1987 он 100 м²-аас дээш) байгалийн болон хиймэл жижиг арлаас бүрдэж байсан ч, сүүлийн үеийн тоо баримтаар / 2023.02.28 / 14125 ш Арал болж нэмэгдсэн байгаа юм. Хүн оршин суудаг 421 арал байна. Токиогоос өмнө зүг хамгийн хол арал нь 1050 км зайтай Огасавара бүлэг арлын Хахажима юм. Мөн НҮБ-н далай тэнгисийн хэлэцээрт заасан далай тэнгисийн эрэг бүхий улс орнууд 200 миль буюу 370.4 км эдийн засгийн онцгой бүс тус улсад хамаарна. Газар зүйн байрлалын хувьд хуурай газраар хиллэдэг улс орон байхгүй юм. Дорнод Хятадын тэнгисээр Хятад, Тайваньтай, Япон тэнгис болон Агнуурын тэнгисээр ОХУ-тай, Япон тэнгисээр Солонгосын хойг буюу БНСУ, БНАСАУ-тай тус тус хиллэдэг. (Ж.Ганхуяг, 2023)

1. Сэнкакү бүлэг арал / せんかくしよとう 尖閣諸島 /

Японоор Сэнкакү, Хятадаар Дяоюйдао хэмээх бүлэг арал нь засаг захиргааны хувьд Окинава мужийн Ишигаки (石垣市) хотод хамаарах ба газар зүйн байршлын хувьд Ишигаки хотоос 150км зайд Зүүн Хятадын тэнгис, гадна талдаа Номхон далайд орших бөгөөд БНХАУ-ын Тайваны зүүн хойд хэсэг болон Японы Кюүшюгийн баруун өмнөд хэсэг хүртэл таран байрлах ба 1000 орчим км сунаж тогтдог Рюүкюү ольтригт хамаарагдана. Рюүкюү бүлэг арал нь дараах 7 хэсэг арлуудаас бүрдэх бөгөөд үүнд Сэнкакү, Сакашим, Дайтоо, Окинава, Оошима, Токара, Оосүми арлууд багтана. Тус бүрдээ олон тооны том, жижиг арлуудаас бүрдэх ба нийт 4670 хавтгай дөрвөлжин км талбайг

эзэлдэг нэр бүхий 50, 400 орчим нэргүй арал таран байрладаг. Хамгийн том арал нь Окинава арал бөгөөд 1211 км² талбай эзэлнэ. Сэнкакү бүлэг арал нь 5.56 км² талбайтай 5 арал, 3 хадаас бүрдэнэ. Үоцүрүшима (魚釣島), Киткожима (北小島), Күбашима (久場島), Тайшѐто (大正島), Минамикожима (南小島), Окинокитаива (沖ノ北岩), Окиноминамиива (沖の南岩), Тобисэ (飛瀬) гэсэн арлууд багтдаг байна. Тус арлыг 2020 оны 12 сарын 1-нээс Тonoширосэнкакү (登野城尖閣) гэж нэрийг Ишигаки хотын хурал баталсан болно. 2012 оны 1 сарын 16-д Японы Засгийн газар эдийн засгийн онцгой бүсэд хамааруулсан байна.

Зураг 1. Дорнод Хятадын тэнгис, Рюүкюгийн бүлэг арлууд



Япон улс Хар тамхины дайны дараа Чин гүрэн доройтох мөчид Мэйжигийн 12 он буюу 1879 оны 3 сард 160 цагдаа, 400 орчим цэрэг илгээн Рюүкюүг эзлэн өөрийн болгож, Окинава муж хэмээн нэрлэсэн. 1894 онд Орос Чин гүрний дайнд ялагдсанаар Чин улс Рюүкюүг Японы эзэмшил нутаг мөн гэж анх удаа хүлээн зөвшөөрсөн байна. Харин 1885 оноос эхлэн Японы Засгийн газар Окинава мужийн захиргаагаар дамжуулан, мөн бусад арга хэлбэрээр Сэнкакү арлуудын талаар нарийвчилсан судалгаануудыг хийсний дүнд тус арлууд дээр хүн байнга амьдарч байгаагүйг нь тогтоон, Манж Чин улсын захиргаанд хамааралгүй гэж үзэн, 1895 оны 1-р сарын 14-ны өдөр Засгийн газар тус арлуудад хилийн шон босгож, Сэнкакү арлуудыг Японы нутаг дэвсгэрт албан ёсоор нэгтгэх тухай шийдвэр гаргажээ. (Japan, 2023) Сэнкакү арлын орчим загас барих зэрэг үйл ажиллагаа явуулдаг байсан Окинава мужийн оршин суугч Кога Тацүширо гэгч (古賀辰四郎) эдгээр арлуудыг түрээсээр ашиглах хүсэлт гаргасныг тухайн үеийн Японы Засгийн газар 1896 онд ёсоор болгожээ. Тус иргэн 30 жил үнэ төлбөргүй эзэмших, хугацаа дууссаны дараа 1 жил төлбөртэй эзэмших зөвшөөрлөө авсаны дараа ажилчдаа арлууд руу илгээн албатрос шувууны өд, сангас цуглуулах, хатаасан хар амар загас бэлтгэх, шүр цуглуулах, мал үржүүлэх, лаазалсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон түлшний зориулалтаар шувууны сангас бэлтгэх бизнес эрхэлж байв. 1902 онд Ишигаки хотын захиргаанд нэгтгэсэн ба 1909 оны тооллогоор 99 өрхийн 248 хүн аж төрж байжээ. 1932 онд уг иргэний хүү Кога Сэнжи /1918-78 он/15000 иенээр 4 том арлуудыг худалдан авсан байна. Улмаар 1940 оноос аж ахуй эрхлэх боломжгүй болсноор уг арлыг орхисноор ажилчид нь ч явж дахин хүнгүй арал болжээ.

Зураг 2. 1896 оны Засгийн газрын түүрээслүүлэх шийдвэр



1945 онд Дэлхийн 2 дайнд Япон улс Америкийн Нэгдсэн Улсад буун өгснөөр Холбоотны дээд командлалын шийдвэрээр Америкийн шууд хяналтанд Сэнкакү арлуудыг оруулжээ. Хэдийгээр 1951 оны Сан Францискогийн гэрээгээр Японы тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн ч Сэнкакү арлын эзэмших эрхийг буцааж өгөөгүй байна. 1975 оны 5 сард Окинаваг буцаан өгснөөр түүний нэг хэсэг болох Сэнкакү арал Японд эргэн ирсэн юм. 1978 онд Кога Сэнжи нас барж, залгамжлах хүн байхгүй болсноор уг арлыг эзэмших эрх найзад нь очив. 2002 онд Японы Засгийн газар зээлээр ашиглах гэрээ байгуулж байсан бол 2012 онд Токио хотын захиргаа уг арлыг худалдан авсанаа зарласан байна.

2. Нутаг давсгэрийн маргаан

1968 онд тус арлуудын орчим газрын тос, байгалийн хийн томоохон орд илэрсэнтэй холбоотойгоор 1971 оноос эхлэн БНХАУ нь тус арал түүхэн үүднээс манай улсад хамаарагдаж ирсэн, эзэмшигч нь Хятад улс байх ёстой гэж Хятадын Тайваны Гийран мужийн нэг хэсэг гэж үзэх болов.

Зураг 3. Хятадын Тайваны Гийран муж ба Дяюйдао бүлэг арлууд



Учир нь 1429 онд Шёо Хашио/尚巴志/ хэмээх хаан Шюри/首里/-г нийслэлтэй Рюүкюү /琉球王国/ буюу /одоогийн Окинаваг/ улсыг байгуулж, 450 жил оршин тогтносон бөгөөд 19 дэх үеийн хамгийн сүүлчийн хаан нь 1872 он хүртэл ёс төдий захирч байлаа. Хэдийгээр 450 жил бие даан оршин тогтнож ирсэн гэх боловч, 14-р зуунд Чюү Зан гэгч хаан Мин улсын хаанд алба өргөж, цол хэргэм авч харьяанд нь орж байв. Мин, Чин гүрэн ч, Японы төв засаг захиргаа ч аль аль нь өөрийн элчин төлөөлөгчийг Рюүкюү улсад нэгэн зэрэг томилон суулгаж өөрийн харьяаны улс гэж үзэж

байсан юм. Япончууд Эдогийн үе буюу 1609 онд захирч нөлөөллөө тогтоохоор довтлоход Рюүкюүгийн хаант улс 4000 цэрэгтэй эсэргүүцэн байлдсан ч ялагдсан тул, япончууд Рюүкюү улсын гадаад худалдаа, дипломат харилцаанд хязгаарлалт хийн хориг тавьж, өөрийн харьяаны улс гэж зарласан. (Ж.Ганхуяг, "XVIII-XX зуунд Японы засаг захиргааны нэгжид гарсан өөрчлөлт", 2021) Гэвч Чин гүрний захиргаанд ч давхар вассал улс хэвээр байсан үе байсан тул Хятад улс дээрх орчмын бүс нутгийг өөрийн эзэмшил гэж хэлэх түүхэн үндэс байж болох талтай.


Гэхдээ 19, 20-р зуун бол колони, дэлхийн 1, 2-р дайны нөлөөгөөр дэлхийн газар зүйн атласт, засаг захиргааны нэгжид өөрчлөлт авчирсан цаг үе байсан бөгөөд зарим улс орнууд газар нутгаасаа хагацаж зарим улс орон өргөжин тэлж, өнөөгийн Дэлхийн хамгийн нийгэмлэгийн дүрэм журамд нийцэж амьдарна хэмээн НҮБ-д элсэн орсож тул өнөө хүчин төгөлдөр үйлчилж буй дэг журамд нийцсэн нотолгоог гаргаж тавих ёстой юм.

Японы Засгийн газрын байр суурь: Сэнкакү арлууд нь Япон улсын газар нутгийн салшгүй хэсэг мөн. (Japan, Northern Territories, 2024)

- Япон улсын Засгийн газрын эзэмшилд шилжин ирсэн нэр бүхий гурван арал нь 1932 онд хувь хүнд худалдах хүртэл Японы Засгийн газрын эзэмшилд байсан бөгөөд эдгээр арлуудыг эзэмшилдээ буцаан авах шийдвэр гаргасан нь Япон улсын дотоодын хуулийн дагуу 2 тэрбум 500 сая иенээр худалдан авах гэрээ байгуулж авсан ба 1 тэрбум 500 сая иен нь хандивын мөнгө юм. Иргэний хуулийн дагаа хөрөнгө шилжүүлэх ердийн үйл ажиллагаа байв. Мөн засгийн газар Тайшөо арлыг өмчлөх өмчлөгч хэвээр байгаа болно.
- Засгийн газрын шийдвэр арлуудыг урт хугацаанд тайван замаар эзэмших, ашиглахын хамт Сэнкакү арлуудын хооронд болон эргэн тойрны далайн тээврийн аюулгүй ажиллагааг хангахад оршиж байгаа болно.
- Сэнкакү арлуудыг Япон улсын газар нутгийн бүрэлдэхүүнд нэгтгэх Засгийн газрын 1895 оны 1-р сарын 14-ны шийдвэр
- Нагасаки дахь Хятадын консулаас ирүүлсэн талархлын захидал
Уг захидалд: Бүгд найрамдах улсын 8 дахь оны (1919 он) өвөл Фүжиан мужийн Хуйан дүүргийн 31 засагчин далайн шуурганд төөрч Японы эзэнт гүрний Окинава мужийн Сэнкакү арлуудын Уайо арлын эрэгт осолдон газардсан билээ. Японы эзэнт гүрний Яэяма дүүргийн Ишигаки тосгоны иргэд аврах ажиллагааг эрчимтэй явуулсны үр дүнд тэд эх нутагтаа эсэн мэнд эргэн ирж чадлаа. Сайхан сэтгэл гарган аврах ажиллагааг хичээл зүтгэл гарган гүйцэтгэсэн тосгоны иргэдэд гүн хүндэтгэлээ илэрхийлэхийн хамт уг захидлаар дамжуулан талархал илэрхийлье.

Нагасаки хотод суугаа Бүгд найрамдах Хятад улсын консул. Бүгд найрамдах Хятад 9 дэх оны (1920 он) 5-р сарын 20-ны өдөр

Зураг 4. Нагасаки дахь Хятадын консулын талархлын захидал




- 1933 оны Хятадад хэвлэгдсэн “Бүгд найрамдах Хятад улсын шинэ газрын зураг”-т, мөн 1958 онд БНХАУ-д хэвлэгдсэн “дэлхийн атлас”-ын 1-р хэвлэл, 1960 оны 2-р хэвлэлд тус тус Сэнкакү арлуудыг Японы бүрэлдэхүүн хэсэг хэмээн харуулсан байдаг.
- Япон улс нь Япон-Чин гүрны дайны дүнд Чин гүрний зүгээс шилжүүлсэн “Тайвань арал болон Пескадорын арлууд”-ыг эзэмшихээс татгалзсан болно.
- Сан-Францискогийн Энхийн гэрээний 3 дахь заалтын дагуу АНУ-ын захиргаанд шилжүүлсэн нутаг дэвсгэрт Сэнкакү арлууд багтаж байсан талаар 1970-аад он хүртэл БНХАУ-ын зүгээс ямар ч эсэргүүцэл мэдүүлж байгаагүй болно.

Хятадын Засгийн газрын байр суурь:

- Мин улсын 5-р он буюу 1372 онд анх энэ арлыг нээсэн хүн хан үндэстэн байсан бөгөөд 1403 он, 1534 он, 1556 он, 1562 он, 1606 он, 1683 он, 1719 он, 1786 он, 1810 он, 1845 он, 1879 он, 1884 онуудад зорчсон тухайн үеийн сурвалжуудад тулгуурласан одоогийн Хятадын Тайваны нэг хэсэг гэж үзэж байна.
- Япон улс нь Сэнкакү арлуудыг Япон-Чин гүрний дайны дүнд Тайваныг булаан авахдаа хамтад нь өөрийн болгосон юм.
- 1943 оны “Кайрын тунхаглал”, 1945 оны “Подстамын тунхаглал”-ыг Япон улс хүлээн авахдаа Тайваны бүлэг арлуудыг Эх газрын Хятад улсад буцаан өгөхийг зөвшөөрснөө биелүүлсэх ёстой.
- Сэнкакү арлууд нь Сан-Францискогийн Энхийн гэрээний 2 дахь заалтын дагуу Японы хураалгасан нутаг дэвсгэрт багтаагүй.
- 1972 онд Япон Хятад хоёр улс дипломат харилцаа тогтоон, 1978 онд Энх тайвны хэлэлцээр байгуулах явцад хоёр улсын удирдагчид Сэнкакү арлуудын асуудлыг түр хойш тавьсан юм.
- 1960 онд хэвлэсэн газрын зургийг 1971, 2023 онд хэвлэсэн Хятад улсын газрын зурагт өөрийн эзэмшил болгон оруулсан.

Зураг 5.Хятадад хэвлэгдсэн газрын зургууд



Сэнкакү арлуудын өнөөгийн байдал:

2008 оны 6-р сард Япон Хятад хоёр улс Дорнод Хятадын тэнгист байгалийн баялагийг хамтран ашиглах талаар санал нэгдсэн бөгөөд Хятад Японы эдийн засгийн онцгой бүс болох Сэнкакү арлуудын хилийн гаднах дундын бүсэд 18 ширхэг цооног барьж байгуулсан байна. Хоёр тал яриа хэлэлцээрийн замаар шийдвэрлэх ёстой гэдгийг аль аль тал нь мэдэж байгаа хэдий ч, өнөө мөрдөгдөж байгаа олон улсын хуулиар Японы талд давуу байдал үүсэх боломжтой тул Хятадын Засгийн газар 2008 оны 12-р сард Японы эзэмшил бүсэд Хятадын далайн хамгаалалтын 2 хөлөг анх нэвтэрсэнээс хойш төрийн мэдлийн болон хувь хүний загас агнуурын хөлөг онгоц бараг өдөр бүр хил зөрчин нэвтрэх болсноос үзвэл нөхцөл байдал хүндрэх төлөв ажиглагдаж байна. Сүүлийн Тайваны Тусгаар тогтнолын асуудлыг тойрсон, Америкийн зүгээс Тайваньд үзүүлэх зэр зэвсгийн хэмжээ нэмэгдэх, Хятадын зүгээс яриа хэлэлцээрийн замаар шийдэгдэхгүй бол цэрэг зэвсгийн хүчээр шийднэ гэх сүрдүүлэг нь энэ бүс нутгийн асуудлыг шийдвэрлэхэд нэн төвөгтэй байдлыг үүсгэж байна.

Дүгнэлт

- Газар нутгийн маргаан эдүгээ цагт магадгүй амар амгалан, асуудлаа шийдсэн мэт харагдавч маргааш юу болохыг таашгүй. Эдийн засаг, улс төрийн ашиг сонирхол, улс орон хүчирхэгжих, доройтохын хамтаар асуудал сөхөгдөнө.
- Тус арлууд дээр хүн байнга амьдарч байгаагүйг нь тогтоон, Манж Чин улсын захиргаанд хамааралгүй гэж үзэн, 1895 оны 1-р сарын 14-ны өдөр Засгийн газар тус арлуудад хилийн шон босгож, Сэнкакү арлуудыг Японы нутаг дэвсгэрт албан ёсоор нэгтгэх тухай шийдвэр гаргажээ.
- Сэнкакү арлуудын 3-ыг өмчлөлдөө буцаан авах шийдвэр гаргасан нь Япон улсын дотоодын хуулийн дагуу хөрөнгө шилжүүлэх ердийн үйл ажиллагаа юм.
- 1919 онд Нагасаки дахь Хятадын консулаас Японы Засгийн газарт ирүүлсэн талархлын захидал, 1933 оны Хятадад хэвлэгдсэн “Бүгд найрамдах Хятад улсын шинэ газрын зураг”-т, мөн 1958 онд БНХАУ-д хэвлэгдсэн” дэлхийн атлас”-ын 1-р хэвлэл, 1960 оны 2-р хэвлэлд тус тус Сэнкакү арлуудыг Японы бүрэлдэхүүн хэсэг нотолно.
- 1968 онд тус арлуудын орчим газрын тос, байгалийн хийн томоохон орд илэрсэн нь нутаг дэвсгэрийн маргааныг сэдрээсэн гэж үзэж болно.
- 2008 оны 6-р сард Япон Хятад хоёр улс Дорнод Хятадын тэнгист байгалийн баялагийг хамтран ашиглах талаар санал нэгдсэн боловч, өнөөдөр ч дайсагнасан байдал үргэлжилсээр л байна.

Japan's territorial policy /Land disputes in East China Sea/

Gankhuyag Jargal

Oriental Languages Department, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Abstract: "Land is the foundation of the country," said the King of the Human Dynasty. In the history of mankind, since the formation of clans, property relations, and the state, the struggle for land has continued uninterruptedly and will certainly continue without end. Today it may seem like problems are solved, but

what will happen tomorrow is unpredictable. The more countries border, the more problems arise, and not only continental countries but also countries surrounded by seas cannot avoid this problem. This presentation discusses the territorial and nominal issues of the disputed maritime border with Japan.

Keywords: territory, treaty of San Francisco, Hague Convention, proof

Ном зүй

foundation, S. p. (2023). *Далай тэнгисийн бодлогын судалгааны төв /Кайёосэйсакукенкюүжёо/*.

Ганхуяг, Ж. (2023). *"Нутаг дэвсгэрийн талаарх Япон улсын баримтлах бодлого" /Солонгосын хойг дахь нутаг дэвсгэрийн болон нэршлийн маргаан /*.

Ж.Ганхуяг. (2021). *"XVIII-XX зуунд Японы засаг захиргааны нэгжид гарсан өөрчлөлт"*.

Харүо, С. (2013). *"Орчин үеийн Японы түүх А"*.

Хирофүми, Я. (2006). *"Японы түүх Б" /ахлах анги,*.